

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ БОЛОН НЭР ДЭВШИГЧДИЙН
АНХААРАЛД**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-56.4-т заасны дагуу сонгуулийн зардлын тайлан гарган Нам, эсвэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч нь санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайландаа хараат бус аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлэхээр заасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ" гэж заасны дагуу зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх тул аймаг дахь төрийн аудитын газраас сонгуулийн зардлын тайланг гаргах жишиг маягтуудыг баталж гаргасан болно.

Зардлын тайлан гаргах, хянуулах, нийтэд мэдээлэхтэй холбоотой сонгуулийн хууль, тогтоомж зөрчсөн тохиолдолд **Зөрчлийн тухай хуулийн** дагуу хариуцлага /мөнгөн торгуулийн/ хүлээх зохицуулалттай болохыг анхаарна уу.

Иймд аймгийн иргэдийн Төлөөгчдийн хурлын сонгуульд оролцсон нам, тухайн намын нэр дэвшигчид зардлын тайландаа хуульд заасан хугацаанд аудитын дүгнэлт гаргуулан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Зардлын тайлан гаргах хавсралт маягтуудыг **audit.mn** вэб сайтад байршуулсан болно.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЫТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2020.10.19

8317144071
БЮА0074 9007245